

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2020 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр**

Тендер шалгаруулалтын нэр: “Аймгийн мал эмнэлгийн газруудад яаралтай дуудлага үйлчилгээнд туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл” худалдан авах тендер

Тендер шалгаруулалтын дугаар: МЭТШ/2020/01-001

Мал эмнэлгийн ерөнхий газар нь эрх бүхий тендерт оролцогчдоос 23 ширхэг “Аймгийн мал эмнэлгийн газруудад яаралтай дуудлага үйлчилгээнд туулах чадвар сайтай тээврийн хэрэгсэл” худалдан авах тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгөөр иж бүрдэлээр нь 50,000 /тавин мянга/ төгрөгөөр худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [30] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

Борлуулалтын хэмжээ: 2019, 2018 оны аль нэг жилийн борлуулалтын орлогын дундаж нь тендерт санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.

Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендерт оролцогчийн санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас дээш байх тухай нотлох баримтыг ирүүлнэ.

Аудитаар баталгаажуулсан санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: 2 жил буюу 2019, 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг ирүүлнэ.

Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Тендерт санал болгож буй үнийн дүнгийн 60 хувиас багагүй байна.

Тендерийн хамт тендерт оролцогч өөрийн санал болгож буй тендерийн үнийн 1 хувьтай тэнцэх төгрөгийн дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2020 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн 11 цаг 00 минутаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2020 оны 02 дугаар сарын 10 -ны өдрийн 11 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцохгүй.

Тендерийг хүлээн авах хаяг:

Худалдан авах ажиллагааны цахим систем Tender.gov.mn цахим хаягт ирүүлнэ.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хаяг: Мал эмнэлгийн ерөнхий газрын 1 дугаар давхар 14 тоот өрөө ,
Засгийн газрын 9 дүгээр байр, Энхтайвны өргөн чөлөө-16/А, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар, Монгол улс Утас: 976-51261639; Факс: 976-51261635**